“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 дүгээр сарын 25 Хөвсгөл аймаг, Тариалан сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11 цагт Хөвсгөл аймгийн Тариалан сумын Мандал багт байрлах тус компанийн байранд эхлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Бат-Эрдэнэ: 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хуралдсан компанийн ТУЗ-ийн хурлаас Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гаргасан ба хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Батхуягийг, Тооллогын комиссын даргаар Б.Юмжирдулам, гишүүдээр Д.Анужин, Б.Сарангарав нарыг томилсон байна.

Хурлын дарга Д.Батхуягийг хурал удирдахыг урьж байна.

Д.Батхуяг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Одоо Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулъя.

ТУЗ-ийн шийдвэрээр байгуулагдсан Тооллогын комисс хурлын ирцийг гаргаж, тооллогын комиссын тогтоолыг танилцуулна.

Б.Юмжирдулам: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2025 оны 04 сарын 03-ны өдрөөр тасалбар болгон авсан бүртгэлээр тус компанийн нийт хувьцаа эзэмшигч: 498 \ давхардсан тоогоор\ , Хувьцааны тоо : 15 734 200 байна.

Үүнээс “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн халаасны хувьцаа болох 783,545 ширхэг хувьцааг хасаад нийт санал өгөх эрхтэй хувьцаа 14 950 655 ширхэг байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 8 558 925 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 9 хувьцаа эзэмшигч оролцож, 3 222 437 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа 8 хувьцаа эзэмшигч урьдчилан саналаа ирүүлснээр нийт саналын эрх бүхий 14 950 655 ширхэг энгийн хувьцаанаас 11 781 362 ширхэг буюу 74.9 хувь болж байна.

\Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав\

Д.Батхуяг:Хурлын ирц хуульд заасан шаардлагад хүрсэн тул Хувьцаа эзэмшигчдийн хурлыг эхлэе.

Өнөөдрийн хуралд компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Энхтогтох, ердийн гишүүн Д.Дуламсүрэн, О.Тунгалаг болон миний бие, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Оюунгэрэл нар оролцож байна. Мөн компанийн гүйцэтгэх удирдлагын багын гишүүд оролцож байгааг мэдэгдье.

Хэлэлцсэн нь:

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2025 оны төсөв, төлөвлөгөө, зорилтын талаар

Танилцуулах нь: Г.Бат- Эрдэнэ - Компанийн Гүйцэтгэх захирал
\танилцуулгыг материалд хавсаргав\

Д.Батхуяг- Бат-Эрдэнэ захирлын танилцуулгаас асууж, тодруулах зүйл байна уу.

Ш.Батдэлгэр \ хувьцаа эзэмшигч\: Надад тодруулах зүйл байна. 2025 онд хийгдэх онцлох ажлууд юу байна вэ?

Г.Бат-Эрдэнэ: Гурилын үйлдвэрийн үйлдвэрлэлийн процессыг хагас автоматжсан горимд шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.

Итгэмжлэгдсэн лабораторийг дахин итгэмжлүүлж, ургамал, хорио цээрийн лабораторийн ажлын хүрээг өргөтгөн, хүний нөөцийг чадавхжуулж ажиллана

Агуулахын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр олох

Тэжээлийн үйлдвэрлэлийн орчин үеийн тоног, төхөөрөмжийг судлах, төсөл, хөтөлбөр боловсруулах, хамрагдах, бүс нутаг дахь малын тэжээлийн зах зээлд томоохон байр суурь эзлэх

Газар тариалангийн хувьд: Бага га-гаас өндөр ургац авах, ОХУ-аас гарц өндөртэй, эрт болцын шинэ сортын үр тариаг туршилтаар тариалах ажлыг эхлүүлэх

Хөрс хамгаалах, хөрсний үржил шимийг сайжруулах, шинэ технологийг нэвтрүүлэх, төслийн хүрээнд зөвлөмжийг хэрэгжүүлж, мөрдөж ажиллах

Технологи нэвтрүүлэхтэй холбоотой техникийн шинэчлэлийг хийх. Технологийн ажилд оролцогч оператор, агрономич нарын ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнд тулгуурлан цалин, хөлс, урамшууллыг олгодог системийг бий болгох, шинэчлэх

Тариалангийн бүх талбайг хашаажуулж дуусгах зэрэг томоохон зорилтууд байгаа.

Мөн ХААИС-д нэг лаборантыг сургаж байгаа. Цаашдаа 2 лаборантаа дахин сургалтад хамруулна.

Д.Дуламсүрэн\ ТУЗ-ийн гишүүн, “Алтан Хажир” ХХК-ийн захирал\ : Манай компани тариалалт хийх үрээ аваад эхэлсэн. ОХУ-ын Эрхүү мужаас. Мөн үрэлгээний шинэ машин худалдан авсан. ОХУ-аас мэргэжилтэн ирж уг машины угсралт, тохиргоог манай ажилчидтай хамтарч хийгээд өнөөдөр буцаж байна.

Ч.Сарангэрэл \ Хуралд оролцогч\ : Миний эцэг Чулуунбаатар гэдэг хүн байсан. Алтандуулга компанийн 7000 ш хувьцаа эзэмшиж байгаад нас барсан. Хөвсгөл бирж дээр нэр нь байдаг. Би энэ хувьцааг өвлөж авсан. Өвлөх эрхийн гэрчилгээ, бичиг баримт нь байгаа. Өнөөдөр хуралд ирсэн боловч миний нэр байхгүй байна. Цаашид яах ёстой талаар зөвлөгөө өгнө үү?

Д.Батхуяг: Та эхлээд аавынхаа хувьцаа эзэмшиж байсан Үнэт цаасны Хөвсгөл бирж дээрээ очиж уулзаарай. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дээр очиж зөвлөгөө авах шаардлагатай байх. Хэрвээ эзэмшиж байгаа хувьцаагаа худалдах саналтай байвал манай компани худалдан авч болно. Манай компанийн халаасны хувьцаа 784 мянга орчим байна. Одоохондоо манай компанийн хувьцааны үнэ буурч байгаа ч цаашдаа үнэ өсөх, хувьцааны үр ашгийг хүртэх боломжтой гэж боддог. Одоогоор таны 7000 ш хувьцаа ойролцоогоор 2,4 сая

төгрөгийн үнэ хүрч байна. Танд зөвлөхөд: Эхлээд асуудлаа хууль, дүрмийн дагуу шийдвэрлүүлж нь зүйтэй гэж хэлэх байна.

Б.Энхтунгалаг \Хувьцаа эзэмшигч\: Би Алтандуулгын нэрийн барааны дэлгүүрт ажилладаг. Өөрсдөө, тариагаа тарьж гурилаа үйлдвэрлэдэг байж гурилаа үнэтэй зарж байна гэж зарим хүмүүс дургүйцдэг. Зуун хүний 20 хүн ийм саналтай байдаг байх. Ихэнх хэрэглэгчид чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан гурилаа хэрэглэж байгаа, азтай хүмүүс гэж ярьдаг.

Би өөрийн зүгээс чадах чинээгээрээ тайлбарладаг. Тог цахилгааны үнэ, бензин шатахууны үнэ зэрэг байнга нэмэгдэж байгаа. Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнэ, өртөг нэмэгдэж байгаа ч харин ч манай компанийн бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

Ш.Батдэлгэр- Манай компанийн гурил үнэхээр чанартай гэдгийг хэрэглэгчид мэддэг. Бусад гурилаас хамаагүй дээр. Үнэ өндөр биш гэж боддог.

Д.Батхуяг- Манай компани ажилчдын цалинд 1,4 тэрбум төгрөг өгдөг. Нийгмийн даатгалд орлогын 26 хувь, татварт 10 хувь, ААН-ийн албан татвар, НӨАТ гэх зэрэг татвар нийлээд 60-70 хувийн татвар төлдөг. Ийм татвар төлдөг тул манайх шиг жижиг компаниуд хөл дээрээ босоход хүндрэлтэй. Энэ жил ХААХҮ-ийн сайд манай компанийн үйл ажиллагаатай газар дээр нь ирж танилцана гэсэн. Энхтунгалаг гуай танаас хүсэх нэг зүйл байна. Та манай гурил, бүтээгдэхүүнийг худалдан авахаар ирсэн хүмүүсийн санал, сэтгэгдлийг бичих дэвтэр нээчих үү? Би ирэхээрээ санал, гомдлоо бичсэн хүмүүстэй биечлэн уулзъя. Компанийн үйл ажиллагаа, нөхцөл байдлаа тухай бүр танилцуулж ажиллъя.Өдөрлөг ч зохион байгуулж болно.

Г.Бат-Эрдэнэ: Санал гомдлын дэвтэр нээж өгье. Сайн, муу бүх сэтгэлийг бичүүлж авч байх. Бид өнгөрсөн 7 хоногт Булганы Хутаг-Өндөр суманд нэрийн барааны дэлгүүрээ нээсэн. Хэрэглэгчид баяртай байгаа ч ижил төстэй бүтээгдэхүүн зардаг болон манай гурилыг зардаг бусад дэлгүүрийн эздүүд дургүйцэж, бага зэрэг эсэргүүцэлтэй тулгарсан. Арга ч үгүй биз. Нэрийн барааны дэлгүүрт гурил арай хямд зарагдах болохлоор.

Ж.Отгонням \компанийн ерөнхий нягтлан бодогч\ Гурил хадгалах 5тонноос дээш агуулах, контейнертэй газарт бид гурилаа нийлүүлж, нэрийн барааны дэлгүүрээ ажиллуулдаг. Тийм газар ховор байна.

Д.Батхуяг- Бид сум болгонд л борлуулалтын цэг ажиллуулах ажиллуулах хүсэлтэй байгаа. Өөрсдөө хүргэлтээ хийнэ. Орон нутагтаа ийм цэг ажиллуулвал зардал чирэгдэл багатай, хүн хүч шаардагдахгүй, боломж байвал байр саваар хангаж өгнө. Энэ жилийн хувьд бүтээгдэхүүний жижиг савлагааны төхөөрөмж авна. Гэрээгээ хийсэн байгаа.Тосны ургамлын тариалалтыг 60 га-д хийнэ. Халтар арвай тариалах төсөл хэрэгжинэ.

Өөр асуух зүйл байна уу? Байхгүй байна. Дараагийн асуудалдаа оръё.

Хэлэлцсэн нь: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Танилцуулах нь:Д.Энхтогтох-ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга
\ ТУЗ-ийн дүгнэлтийг материалд хавсаргав\

Д.Батхуяг: Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуух асуулт байна уу?
Асуулт байхгүй байна.
Үг хэлэх, санал гаргах хүн байна уу?

О.Тунгалаг\ ТУЗ-ийн гишүүн\: 2025 оны 3 сард ТУЗ хуралдсан. Тус хуралд оролцсон гишүүд 2024 оны Компанийн үйл ажиллагаанд "хангалттай" гэсэн үнэлгээ өгсөн байгаа. Өнгөрсөн онд импортын гурилын татвар өөрчлөгдөн, санхүү, эдийн засгийн хүндрэлтэй байсан ч бага зэрэг ашигтай ажилласан байна. Компанийг улам үр ашигтай ажиллах талаар цаашдаа ямар асуудалд анхаарч ажиллах талаар ТУЗ-ийн гишүүд тодорхой саналууд гаргасан. Түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр анхаарч ажиллана гэж найдаж байна. Миний бие анх удаа Тариалан суманд ирж байна. Манай компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бааз, тоног төхөөрөмж сайн, өнгөцхөн танилцахад сайхан сэтгэгдэл төрүүлж байна. Компанийн хувьцаа эзэмшигчид, ажилтан, ажилчидтай уулзаж ярилцана. Санал хүсэлтийг сонсоно. Компанийн дотоод ажилтай танилцаж, зөвлөгөө өгнө гэж бодож байгаа.

Д.Батхуяг: ТУЗ-ийн гишүүн О.Тунгалаг эгч маань УИХ-ын Тамгын газрын Төрийн байгуулалтын хэлтэст ахлах зөвлөх хийж байсан хүн тул асуух, зөвлөгөө авах зйүл байвал асуугаарай.

Д.Энхтогтох\ ТУЗ-ийн гишүүн\: Сүүлийн үед ХАА, газар тариалангийн салбарыг сонирхож түүнд хөрөнгө оруулах байгууллага, хүмүүс байхгүй болсон байна. Уул уурхай, банк, ББСБ-д хөрөнгө оруулж хувьцаа худалдан авах сонирхол давамгайлж байна. Цаашдаа Төсөв, төлөвлөгөөгөө хийхдээ олон вариант, хувилбараар хийж танилцуулж байх үүргийг компанийн гүйцэтгэх удирдлагад өгч байгаа.

Д.Батхуяг: Манай компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд нэр хүнд бүхий хөндлөнгийн Аудитын компани дүн шинжилгээ хийдэг. Аудит буруу зөрүү ажиллавал тухайн байгууллагыг цаашид хүлээн зөвшөөрөхгүй, нэр хүнд нь ч унадаг. Бидний зүгээс бүх асуудлаа хуулийн дагуу хийдэг. Санхүү бүртгэл нээлттэй. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудаст мэдээлэгддэг. Та бүхэн Биржийн сайт руу орж танилцаж байгаарай.

За дараагийн асуудалдаа оръё.

Хэлэлцсэн нь: ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийн талаар

Танилцуулсан нь: Д.Батхуяг

Та бүхэнд ХЭХ-аар хэлэлцэх асуудлуудыг ном хэлбэрээр хувилж тараасан. Танилцсан байх.

Асуулт байна уу? Байхгүй байна.

Хэлэлцсэн нь: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай

Танилцуулсан нь: Д.Батхуяг:

Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны хурлаас "ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай" 04 тоот тогтоол гаргасан. ТУЗ-ийн гишүүдийн урамшууллын хэмжээг баталсан байдаг. ТУЗ-ийн хараат бус гишүүд сард 70000, энгийн гишүүд 50000, хороодын даргын нэмэгдэл 30000 төгрөг, ХЭХ, ТУЗ-ийн хурал, хороодын хуралд оролцсон оролцооны урамшуулал 50000 төгрөг байдаг. ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга тогтмол цалин авдаг. Энэхүү тогтоолоо цаашид мөрдөж явах юм.

Асуух асуулт, санал гараагүй болно.

Д.Батхуяг: Ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-өөс гаргасан тогтоолыг эзэмшигчдэд танилцуулах ёстой.

Ногдол ашиг хувиарлахгүй болсон шалтгаан, үндэслэлээ Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн хуралд танилцуулсаны үндсэн дээр ТУЗ-өөс шийдвэр гаргасан. Тараасан материалд байгаа. Та бүхэн танилцсан байх.

Асуулт байна уу? Байхгүй байна.

За одоо санал өгөх ажиллагааг эхлүүлэв.

Д.Батхуяг:Санал хураалтын дүнгийн талаар Тооллогын комиссын дарга Б.Юмжирдулам танилцуулна. \ Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав.\

Д.Батхуяг: ХЭХ-аас гарах тогтоолын төслийг уншиж, батлуулъя.

Тогтоолын төсөл дээр өөр саналтай хүн байна уу? Байхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолуудыг батлав. Тус хурлаас нийт 3 тогтоол гарсан ба хувьцаа эзэмшигчид 100 хувийн саналаар батлав.

Хуралд идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигчид Та бүхэндээ баярлалаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хаасныг мэдэгдье.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 12 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

Хурлын дарга: Д.Батхуяг

Тэмдэглэл хөтөлсөн ТУЗ-ын нарийн бичгийн дарга: С.Оюунгэрэл

ХӨВСГӨЛ АЛТАН ДУНГА ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
АТА5488 № 2034565